

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2020 ОНЫ 03 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 7 өргөдөл бичгээр хүлээн авч, 6 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 14 өргөдөл бичгээр хүлээн авч, 13 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 3 өргөдөл бичгээр хүлээн авч, 3 өргөдлийг шийдвэрлэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 91,6 хувьтай байна.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 1 сувгаар 9 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 9 санал хүсэлт ирүүлснээс гомдол 1, санал хүсэлт 8 бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 9 иргэний санал хүсэлтэд хариу өгч, шийдвэрлэлт 100 хувьтай байна. Үүнд орчны эрүүл ахуйн асуудлаар 3, хууль эрх зүйн асуудлаар 1, бусад асуудлаар 5 иргэн тус тус хандлаа.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл бүртгэгдээгүй, Засгийн газрын 1111 төвд 3 дугаар сард санал хүсэлт ирээгүй болно.

Нэг цонхны үйлчилгээ аймгийн ЗДТГ-т байрлаж Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 12 төрлийн үйлчилгээгээр 429 иргэнд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр 2847 иргэнд нийт 5 мэргэжилтэн 27 төрлийн үйлчилгээгээр 3276 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Аймгийн Онцгой комиссын ажлын талаар: Аймгийн Онцгой комисс тайлант 3 дугаар сард 6 удаа хуралдаж аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 23 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 7 шийдвэр, аймгийн Засаг даргын 5 захирамж, Онцгой комиссын даргын 8 тушаал, албан даалгавар 2, үүрэг хүргүүлэн холбогдох албан бичиг боловсруулан гаргаж хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Аймгийн Онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Хуваарь батлах тухай” тушаалаар Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Авто тээврийн төвийн 49 алба хаагч, 12 техниктэйгээр 10 хяналтын постод, 2 хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулсан. “Зарим арга хэмжээг түр хугацаагаар хориглох тухай” аймгийн Засаг даргын 2020 оны А/131 дугаартай захирамжаар Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр, Монгол цэргийн өдөр, Наурызын баяр зэрэг тэмдэглэлт өдөр нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон.

“Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр зогсоох тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ны А/151 дүгээр захирамжаар аймаг, сумын нутаг

дэвсгэрээс гарах, орох хот хоорондын зорчигч тээвэр, хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 08:00 цагаас 03 дугаар сарын 16-ны өдрийн 08:00 цаг хүртэл түр зогсоож 27 хяналтын постууд гарган хяналт тавин ажиллалаа. Аймгийн Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 01 -ний өдрийн 03 дугаар шийдвэрийн 15 дугаар заалтад 0-5 насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд 5 хоногийн цалинтай чөлөө олгох асуудлыг байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулахыг төрийн албаны удирдлагуудад үүрэг болгож, хувийн хэвшлийн байгууллагуудын удирдлагуудад чиглэл өгч ажиллалаа. 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 31 байгууллагын нийт 265 эцэг эхчүүдэд цалинтай чөлөө олгоод байна. Буддын шашны хийд 9, Христийн шашны сүм 9, Исламын шашны сүм 5, нийт 24 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Дээрх сүм хийдээс албан ёсны бүртгэлтэй 19, сумдад үйл ажиллагаа явуулдаг 5 сүм хийд бүртгэлгүй байна.

Шашны зөвлөлд үйл ажиллагааны зөвшөөрөл хүсч, шинээр сүм хийд байгуулахаар Исламын шашны 1, буддын шашны 1, Христийн шашны 3 сүм хийд хүсэлт ирүүлсэн. Цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, сунгах асуудлыг түр зогсоосон.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 3 дугаар сард улсын төсвийн санхүүжилт 18458.3 сая төгрөг ирэхээс 17320.3 сая төгрөг ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 1627.5 сая төгрөгийн санхүүжилтээс 489.4 сая төгрөгийн санхүүжилт ирж сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэгт 3946.7 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 1915.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтээс сургуульд 7570,4 сая төгрөг, цэцэрлэгт 3655,9 сая төгрөг, хүн эмнэлэгт 1476,1 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 134,6 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 142,3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

Шинэ коронавирусын тархалттай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хэмнэгдсэн үдийн цай, хоолны зардлыг сургууль, цэцэрлэгт ариутгал, халдваргүйтлийн материал худалдан авахаар аймгийн Засаг даргын А/162 дугаар захирамжаар тус байгууллагуудын 3 дугаар сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан зохицуулалт хийж баазыг Сангийн яаманд хүргүүлж батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийн эрхийг нээлгэлээ.

Мөн коронавирусийн халдвартай холбоотой улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажилласнаар Төсвийн захирагчдын 2020 оны батлагдсан төсвийг хэрэгжүүлэх явцад зарим зардалд /үдийн цай, хүүхдийн хоол, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, урсгал засвар, төсөв батлагдсан боловч хэрэгжихгүй болсон төсөл, хөтөлбөр арга хэмжээний зардал/ зарцуулагдаагүй үлдэгдэл үүсч байгаа бөгөөд тус зардлыг зохицуулах, зарцуулах асуудлыг зөвхөн эрх

бүхий дээд шатны байгууллагуудын шийдвэрийг үндэслэн Төсвийн ерөнхийлэн захирагчийн шийдвэрээр зохицуулж зарцуулахыг аймгийн Засаг даргын 1/488 дугаар албан бичиг хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Нягтлан бодогчдод санхүүгийн тайланг хуулийн хугацаанд боловсруулан И-тайланд шивүүлэхэд анхаарч, зөвлөгөө өгч ажилласнаар тайлангийн шивэлт 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Аж ахуйн нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд И-баланс системд цахим хэлбэрээр хүлээн авах, хянан баталгаажуулах, бүртгэлийн алдааг залруулж аргагүйгээр ханган ажиллалаа. Нийт 1814 аж ахуйн нэгж байгууллагын тайлан хүлээн авахаас 1546 тайланг авч баталгжуулсан нь 85,2 хувийн гүйцэтгэлтэй байна. Шинээр үүсгэн байгуулсан 86 аж ахуйн нэгжийн цахим системд нэвтрэх эрх олгож мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, аж ахуйн нэгж байгууллагуудын бүртгэлийг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулсан.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 6335 ширхэг зардлын ваучер бичиж, 17080,2 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийж ажиллав. Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 1442 аж ахуйн нэгж, хувь хүний мэдээллийг засварлаж, шинээр орууллаа.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаа, Ховд сумын төсөвт байгууллагуудын 2016-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар ур чадварын нэмэгдлийг хувь хэмжээнээс давуулан илүү олгосон, сургуулийн захиралд мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон, авлага өглөгийг данс бүртгэлд тусгаагүй, засварын ажилд тендер зарлаагүй, шууд худалдан авах гэрээ байгуулсан, багш нарт мэргэжлийн зэргийн нэмэгдэл дутуу олгосон, мэргэжлийн зэргийн хугацаа дууссан багшид нэмэгдэл олгосон, зөөврийн компьютер дутагдуулсан, тэтгэмж олгох болзол шаардлага хангаагүй багшид тэтгэмж олгосон, цалингийн урьдчилгааг суутгаагүй авлага үүсгэсэн зэрэг зөрчил дутагдлуудыг илрүүлж, 10380,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод, 27105,2 мянган төгрөгийг хөрөнгө орлогод авахуулахаар улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

Ховд сумын төсөвт байгууллагуудын сүүлийн 4 жилийн санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт хийгдэж ажлын явц 85 хувьтай байна. Тус байгууллага нь албан ёсны цахим хуудас болох www.sankhuu.kho.gov.mn хуудсаар байгууллагын мэдээ мэдээлэл, төлөвлөгөө, санхүү төсвийн мэдээллүүдийг ил тод байршуулж олон нийтэд мэдээлж байна.

Татварын хэлтэс тайлант хугацаанд бүртгэгдсэн ААНБ-уудыг аймгийн улсын бүртгэл, статистикийн газартай тулгалт хийж Тахаст болон Trips программд бүртгэлээ. Үүнд: ХХК 5, Нөхөрлөл 1, төрийн бус байгууллага 1, сан 1, нийт 7 аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдлээ.

Төрийн сангийн цахим сайтаар дамжуулан татварын орлогын хуулгуудыг өдөр бүр нэр төрөл бүрээр авч татварын мэдээллийн санд боловсруулалт хийлээ. Мөн

татварын данс андуур ч орсон 3 татвар төлөгчтэй холбоотой 2 төрлийн татварын 1,5 сая төгрөгийг залруулах бичилт хийсэн байна.

Хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулах, бүхий л эх үүсвэрийг татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж хэвших, хөндлөнгийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлтийг хангаж ажилласнаар 19 хамаарагчтай 8 агуулагчтай татвар төлөгчийн 25 ширхэг 102,4 сая төгрөгийн хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулав.

Улс, аймаг, сум орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 2020 оны 3 дугаар сарын 31-ны байлаар 3000.3 сая төгрөг оруулахаас 3512.0 сая төгрөг буюу 117.0 хувьтай байна. Үүнээс улсын төсөвт 657.0 сая төгрөг оруулахаас 1097.5 сая төгрөг буюу 167 хувийн, аймгийн төсөвт 1881.4 сая төгрөг оруулахаас 1915.3 сая төгрөг буюу 101.8 хувийн, сум орон нутгийн төсөвт 461.9 сая төгрөг оруулахаас 499.2 сая төгрөг буюу 108.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Статистикийн хэлтсийн салбар хариуцсан мэргэжилтэнгүүд 32 төрлийн мэдээний 1193 аж ахуйн нэгжээс дотоодын нийт бүтээгдэхүүн тооцдог ААНБ-1 болон ААНБ-2 маягтаар мэдээллийг бүрэн цуглуулж програмд шивж Үндэсний статистикийн хороонд хүргүүлээ.

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг Жаргалант сумын Жаргалан, Магсаржав багт, Алтай сумын Алтангадас багт, Зэрэг сумын Бургасан багт, Чандмань сумын Тахилт багт, Мянгад сумын Цагаанбулан багуудад тус тус хийж гүйцэтгэлээ. Ажиллах хүчний судалгааг Булган сумын Бүрэнхайрхан, Үенч сумын Хөх үзүүр, Манхан сумын Төгрөг гол, Чандмань сумын Сүлжээ багуудад хийж байна.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Захиргааны болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 4 шүүх хуралдаанд хариуцагчийг төлөөлж оролцож байна. Шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхээс шаардсан нотлох баримтуудыг нотлох баримтын шаардлага хангуулан хугацаанд нь гаргаж хүргүүлээ.

Авлигатай тэмцэх газарт шинээр томилогдсон 1 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүргүүлээ. Шүүхийн шийдвэрээр буцаан томилогдсон 4 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд бүртгэлээ.

Нотариатын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу нотариатын үүрэг хавсран гүйцэтгэгч нь Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс олгосон дугаар бүхий тогтоосон загварын дагуу үйлдсэн тамга, баталгааны тэмдэг хэрэглэнэ гэж заасан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Баталгааны тэмдгийн загвар батлах, нотариатын үүрэг хавсран гүйцэтгэгчийн баталгааны тэмдгийн дугаар олгох тухай” 2019 оны А/210 дугаар тушаалаар баталгааны тэмдгийн загварыг батлан ирүүлсэний дагуу нотариатын тамга, баталгааны тэмдгийг шинэчлэх ажлын хүрээнд аймгийн “Голден нетворк” ХХК-д захиалга өгч аймгийн 16 сумын Засаг даргын Тамгын газрын дарга хавсран гүйцэтгэдэг нотариатын тамга, тэмдгүүдийг бүрэн шинэчлэв.

Хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд “Төрийн болон албаны нууцыг хамгаалах журам” боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 70 дугаар тушаалаар батлуулж, аймгийн Тагнуулын газраар хянуулан 17 сум, 22 агентлагт хүргүүлээ.

Шүүхийн шинжилгээний алба: Монгол Улсын хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын тушаал, албан даалгавар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2020 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэр, цаашид хэрэгжүүлэх саналыг биелүүлэх зорилтын хүрээнд 17 албан бичиг хүлээн авч байгууллагаас 13 бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллалаа. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах 2019-2020 оны сургалтын хөтөлбөр боловсруулан баталж төлөвлөгөөний дагуу тайлант сард 2 сэдвээр 2 цагийн сургалт зохион байгуулсан.

Эд эсийн шинжилгээг дамжуулж, блокыг дагалдах хуудсын хамт ШШҮХ-нд хүргүүлж хариуг албаны цахим khovd_nifs@yahoo.gov хаягаар авч ажиллаж байна. Албаны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ, гүйцэтгэлийн болон бусад төлөвлөгөөний биелэлтүүдийг тооцож, хугацаанд нь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргүүлэв.

Албаны үйл ажиллагааны явцад бий болсон 2019 оны түр хадгалах 14, 70 жил хадгалах 1, байнга хадгалах 36, нийт 51 хадгаламжийн нэгжийг архив зүйн шаардлагын дагуу эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж бүрдүүлэн, бүртгэлээр архивын ажилтанд хүлээлгэн өглөө. 2020 оны 01 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд албаны үйл ажиллагааг сурталчлан Мөнххайрхан, Манхан, Зэрэг, Дарви, Чандмань зэрэг сумдад “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгууллаа.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 3 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 66, эд эсийн шинжилгээ 3, тусгай шинжилгээ 4, криминалистикийн шинжилгээ 5 тус тус хийж, дүгнэлт гаргасан. Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 24 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 130 ширхэг мөр, гутлын мөр 20, гарын мөр 23, тээврийн хэрэгслийн мөр 21, эвдлэгч багажны мөр 2, биологийн гаралтай ул мөр 20, бусад ул мөр, 44 эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 74, гарын мөр 4 авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийлээ. Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох, бүтцийн, химийн, биологийн, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүд болон ирүүлсэн тогтоолуудыг тухай бүрт нь цахим санд оруулж ажиллав.

Цагдаагийн газар: Тайлант сард иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Улсын хэмжээнд явагдсан “Хайр өвтгөдөггүй”, “Архигүй орчин” зэрэг нөлөөллийн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт салбар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллав. Аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 2020 оны 03 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд Манхан, Булган сумын эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд шаардлагатай хариу үйлчилгээг үзүүлсэн. Гэмт хэргийн хохирогч болон холбогдогч хүүхдүүдийн гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, эцэг, эх асран хамгаалагчтай нь уулзаж, дахин учирч болох болзошгүй эрсдэлээс хамгаалах хариуцлагын гэрээ байгуулж хяналтад авч ажиллав.

Арга хэмжээний хүрээнд үйлчилгээний байгууллагын цагийн хуваарь болон үйл ажиллагааг түр хугацаагаар хориглох зэрэг цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор Цагдаагийн газрын нийт алба хаагчид нэмэлтээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж баар ресторан, дэлгүүр, архи согтууруулах ундаа худалдан борлуулах үйлчилгээ үзүүлдэг давхардсан тоогоор 182 аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж, 25 зөрчил илрүүлж холбогдох хууль тогтоомжоор 4.310.000 төгрөгийн торгууль оногдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор яриа таниулга хийж 150 санамж, сэрэмжлүүлгийг facebook цахим хуудаст байршуулан орон нутгийн “Ховд” телевизээр иргэд олон нийтэд мэдээлэв.

Мөн хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах зорилгоор 2020 оны 03-р сарын 16-ны өдөр 2 удаагийн давтамжтай орон нутгийн Ховд телевизэд 3 удаа яриа өгч ажилласан. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хэргээр буюу 16.6 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гомдол мэдээлэл 10 бүртгэгдсэн нь 6 гомдол мэдээллээр буюу 2.5 дахин өссөн. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 8 гомдол мэдээлэл мэдэгдэж, холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран цагдаагийн газрын эрүүлжүүлэх, баривчлах байранд баривчлагдсан 38 этгээдэд “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөрт 2 цагийн албадан сургалтыг 18 удаа зохион байгууллаа.

Цагдаагийн газрын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс “Хайр өвтгөдөггүй” аяны логотой 100 ширхэг амны хаалт хийж, цагдаагийн газраар үйлчлүүлж буй иргэд, баривчлагдсан этгээдүүдэд тарааж үйлчлэв.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран архины хамааралтай гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарын судалгааг гаргаж, 10 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулж, ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулж байна. “Хайр өвтгөдөггүй” арга хэмжээний мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд сурталчлан 120 аж ахуйн нэгж байгууллага болон гудамж талбай, олон нийтийн газар, орон сууцны

хаалга, бүх төрлийн мэдээллийн самбар зэрэгт 480 ширхэг зурагт хуудсыг тараан байршуулсан.

Орон нутгийн “Ховд”, “Олон ястны” телевиз, “Гэр бүлийн радио” 104, Тэмүүлэл fm 89.1-тэй хамтран байгууллагын үйл ажиллагаа болон улс, орон нутгийн хэмжээнд зохион явуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэвтрүүлэг 1, зочны буюу ярилцах цаг 3, 12 мэдээ сурвалжлагыг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэж, “Khovd.mn”, “Монцамэ”, “Khovdnews.mn” сайтад 5 удаагийн ярилцлага, мэдээлэл нийтлүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2020 оны 2 дугаар сарын 25-аас 2020 оны 3 дугаар сарын 25-ны байдлаар нийт 272 гомдол мэдээлэл хүлээн авсны 78 буюу 28,6 хувийг гэмт хэргийн шинжтэй, 194 буюу 71,3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна. Бүртгэгдсэн 47 гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 3, Хулгайлах гэмт хэрэг 10, Мал хулгайлах 8, Залилах гэмт хэрэг 2, Хүчиндэх 1, Дээрэмдэх гэмт хэрэг 2, Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 1, Хөрөнгө завших 1, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 3, бусад гэмт хэрэг 2 тус бүртгэгдсэн байна.

Хүлээн авсан гомдол мэдээллийг төрлөөр нь авч үзвэл: Бусдын биед халдах 9, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 15, Залилах 6, Дээрэмдэх 1, Зам тээврийн осол 14, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 3, Мал хулгайлах 6, ОНАТБА 18, Хулгайлах 18, Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 21, Хууль сахиулагчийг эсэргүүцэх 4, Хүчиндэх 3, Хүрээлэн байгаа орчны эсрэг 6, Хөрөнгө завших 2, Худалдаа үйлчилгээний журам зөрчсөн 7, Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2, Бусад 137 гомдол мэдээлэл тус тус хүлээн авч шийдвэрлэв.

Дээрх хугацаанд зөрчил гаргасан 186 хүнийг эрүүлжүүлж, зөрчил гаргасан 239 хүнийг 48,410,000 мянган төгрөгөөр торгож, хурд хэтрүүлсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 71 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 32 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулсан болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар – 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон ангийн хэвийн үйл ажиллагаа, хоригдол, хоригдогч нарын аюулгүй байдлыг хангах, тэдний дундаас гарч болзошгүй аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хоригдлыг нийгэмшүүлэх ажлын чиглэлээр төлөвлөгөөний дагуу сургалт, үйл ажиллагааг зохион байгууллаа. Ангийн харуул хамгаалалтыг “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ын дагуу зохион байгуулж, алба хаагчдын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, манлайлан ажиллах, ажилдаа хандах хандлагаа дээшлүүлэн ажиллахыг үүрэг болгов.

Шинэ төрлийн короновирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн хүрээнд 2019-2020 онд зохион байгуулагдах сургалтыг тасралтгүй явуулах зорилгоор

танхимын бус хэлбэрээр хичээл сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулж, алба хаагчдыг бүрэн хамруулан ажиллаж байна.

Алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх багаар ажиллах чадварыг нэмэгдүүлж, мэргэжлийн мэдлэг, эрдэм шинжилгээний ажил, судалгаа хийх арга зүйг дээшлүүлэх, зорилгоор нийт алба хаагчдыг 6 баг болгон албан хэрэгцээнд өргөн хэрэглэгддэг хууль, дүрэм журмаар гарын авлага гаргах уралдаан зарласан бөгөөд 2020 оны 03 дугаар сарын 30-ний өдөр шалгаруулахаар төлөвлөн ажиллаж байна. Уралдаанд шалгарсан гарын авлагыг ангийн захиргааны дэмжлэгтэйгээр хэвлүүлж албан хэрэгцээнд ашиглах бөгөөд 2020 оны 12 дугаар сард Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын “Шилдэг бүтээлийн уралдаан”-д оролцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн А/42 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын англи хэлний мэдлэгийн төвшинг дээшлүүлэх” “Гадаад хэл-мэдлэгийн түлхүүр дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2019 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн “Сургалт зохион байгуулах” тухай А/41 дүгээр тушаалын хүрээнд “Гадаад хэлний мэдлэг, хэрэглээний чадварыг дээшлүүлэх” талаар 1 багц цагийн сургалтыг 2019-2020 оны өвөл цагийн сургалтын төлөвлөгөөнд тусган 2020 оны 1, 4 дүгээр улирлуудад Ховд Их Сургууль, Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн “Гадаад хэлний сургалтын төв”-ийн тусгай хөтөлбөрөөр алба хаагчдад “Англи” хэлний анхан болон дунд шатны сургалт зохион байгуулахаар төлөвлөгөө батлуулсан.

2. Ховд их сургууль, Нийгэм Хүмүүнлэгийн ухааны сургуулийн “Гадаад хэлний сургалтын төв”-тэй хамтран ажиллах талаар албан тоот хүргүүлсэн бөгөөд алба хаагчдын нэгдсэн albakhaagch457@gmail.com хаягаар “Англи хэлний анхан шатны” хичээллүүдийг файл хэлбэрээр оруулж алба хаагчид цахим хэлбэрээр бие даан судалж байна.

3. “Гадаад хэл-мэдлэгийн түлхүүр дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үүднээс ангийн хэмжээнд төлөвлөгөө гарган, алба хаагчдаас англи хэлний түвшингийн талаар цахимаар судалгаа авч түүнд нийцүүлэн түвшинд тохирсон цахим хичээллүүдийг явуулж байна.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тайлант сард нийт 1936 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 1345, Үүнээс: Гадаад паспорт олголт - 76, Иргэний үнэмлэх шинээр олгосон 98, сунгалт 127, дахин олгосон 77, Иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэл 324 Үүнээс: Төрөлт 196, Үрчлэлт 9, Овог, эцгийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл 10, Эцэг тогтоолт 3, Гэрлэлт 39, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 1, Нас барсны бүртгэл 40, Нөхөн бүртгэл 22, Регистр олголт 4, Иргэний бүртгэлийн лавлагаа олголт 643, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 427, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 149 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллав. Иргэдээс нийт 15 өргөдөл, санал хүсэлт ирснээс хуулийн

хугацаанд 7 өргөдөлийг шийдвэрлэж, 2 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлэн, 6 өргөдлийн хугацаа болоогүй хүлээгдэж байна.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: Боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийг дүгнэж тайлагнах, мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж анги дэвших шалгалтын даалгаврын сантай болохоор бюпринтийг хүргүүлж, жишиг даалгавар боловсруулахад анхаарч ерөнхий боловсролын 3 дугаар ангийн сурагчдаас математик, монгол хэл, хүн орчин, дүрслэх урлаг технологи хичээлийн, 4 дүгээр ангийн математик, монгол хэл, хүн байгаль, хүн нийгэм, дүрслэх урлаг, технологи хичээл, 6-11 дүгээр ангийн монгол хэл, 10-11 дүгээр ангийн хими, биологийн хичээлийн анги дэвших шалгалтын даалгаврын санг багш нартай хамтран хийж, 9 дүгээр ангийн хими, 8 дугаар ангийн эрүүл мэндийн хичээлийн хөндлөнгийн шалгалтын сэдэв боловсрууллаа. 12 дугаар анги төгсөгчдийн ЭШ-ын бэлтгэлийг эрчимжүүлэх, урьдчилсан түвшин тогтоох, цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол, соёл, урлагийн газраас “ЭШ-ын өмнөх их сорилго” шалгалтыг 3 удаа авахаар төлөвлөсөн ба Сорил 3-ын сэдвийг 10 хичээлээр боловсруулан бэлэн болгож, цахимаар авах боломжийг судалж байна. /Googledocs программ ашиглан тестээ бэлтгэлээ./

Боловсролын чанарын шинэчлэл төслөөс ирсэн чиглэлийн дагуу сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 4 дүгээр шатыг хэрэгжүүлж байгаа Алтай, Мөнххайрхан, Дарви, Мянгад, Буянт, Эрдэнэбүрэн, Жаргалантын 1,2,3,6,7, Прогресс сургуулийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлын төсөв хийж, төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүллээ.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хөл хорионы үед ажиллах сургуулийн өмнөх боловсролын теле хичээлийн агуулга, хичээлийн хуваарийг хүргүүлж, зарим хичээлийн агуулгад хэрхэн ажиллах, гэр бүлд эцэг эхчүүдтэйгээ хэрхэн харилцах талаар зөвлөмж боловсруулж хүргүүллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон зуны хувилбарт сургалтын хөтөлбөрийн талаар зөвлөгөөг цэцэрлэгийн эрхлэгчдэд өгөв. Телевизийн хичээлээс гадна багш нарын нэмэлт хичээл бэлтгэж байгаа багш нарт 5 цагийн зөвлөгөө өгч ажиллав. Боловсролын хүрээлэнгээс ирүүлсэн “Иргэний ёс зүйн боловсрол” хичээл заадаг багш нарын дэлгэрэнгүй судалгааг авч нэгтгэн хүргүүллээ. Судалгаанд 1-12 дугаар ангид 379 багш 16992 сурагчдад “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг зааж байна.

Хорио цээрийн үед "Иргэн" төслийг энэ хичээлийн жилд цуцалж өмнө хичээлийн жилд хэрэгжүүлсэн төслийг "Сайн туршлага" хэлбэрээр poster бэлтгэн олон нийтийн сүлжээгээр түгээхээр төслийн багийнхантай хамтран ажиллаж байна.

2020 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу өвчний дэгдэлтийн 4, 5 дугаар эрэмбэлэлтэд сумдын сургуулийн дотуур байр, спорт заал, цэцэрлэгийн барилгыг тусгаарлах байр болгон ашиглах, бэлэн байдлыг хангах чиглэлийн дагуу 25 сургуулийн бэлтгэл хангуулсан.

Дотоодын их, дээд сургууль, коллежид суралцахдаа Боловсролын зээлийн сангаас сургалтын төлбөрийн зээл авсан иргэд нь холбогдох журам, гэрээнд заасан үүргээ биелүүлсэн тохиолдолд зээлийг хөнгөлөх, чөлөөлөх журмын төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан. Гэрээний үүргээ биелүүлэн хөдөлмөр эрхэлж буй салбарын албан хаагчдын дипломыг буцаан олгох боломжийн талаарх судалгааг хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу гарган 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдөр БСШУСЯ-нд хүргүүлсэн. Эдгээрт нийт 79 байгууллага хамрагдаж баримт бичиг нь зээлийн санд хадгалагдаж байгаа албан хаагчдын тоо 65 байна.

НТБ-ын модуль нэвтрүүлэхтэй холбоотой бичиг үсэг, НТБ-ын үндсэн 6 чиглэлийн сургалтыг явуулдаг НТБТ, ЕБС-иуд сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, Улсын бүртгэлийн гэрчилгээг manage@ncle.edu.mn мэйл хаягаар Боловсролын удирдлагын мэдээллийн системийн багт илгээв.

Боловсролын салбарын 59 байгууллагын цэцэрлэгийн хүүхдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны хэмнэгдэж буй зардлаас 105,2 сая төгрөгийн зардлыг онцгой байдалтай холбоотойгоор ариутгал, халдваргүйтгэл, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, нормын хувцасны зардалд зарцуулахаар аймгийн Засаг даргад санал танилцуулж, төсвийн зохицуулалт хийж цэцэрлэг сургууль бүрд 8 нэр төрлийн ариутгал, халдваргүйтгэлийн бодис, багаж, хувцас зэргийг авах жагсаалтыг гаргаад байна.

Жаргалант сумын сургуулиудад сурагчдын ширээ, сандал нийлүүлэх 35 сая төгрөгийн өртөгтэй ажлын даалгавар боловсруулж, аймгийн орон нутгийн өмчийн газарт хүргүүлж тендер шалгаруулалт зарлаад байна.

Соёлын чиглэлээр: Ховд сумын Баянбулаг багийн давдагын Хөтөлийн буган хөшөө цогцолбор, Булган сумын Авын хөх уул, Ховд сумын Баянбулаг багийн нутагт байрлах Баянбулагийн хиргисүүрүүд, Буянт сумын Наранхайрхан багийн Далтын ус, Дарви сумын Мөнгөн аяга багийн нутагт байгаа Жүргэрийн цагаан толгойн руни бичээс, Дарви сумын Булаг багийн нутагт байгаа Загал баатрын булш, Булган сумын Баян гол багийн нутагт байгаа Зурагтын хадны зураг, Буянт сумын Норжинхайрхан багийн нутаг Норжинхайрханы хадны зураг, Манхан сумын Тахилт багийн Нүхэн өтгийн хадны зураг, Мянгад сумын Самбуу толгойн буган хөшөөд, Үенч сумын Харгайтын бэлчрийн хадны зураг зэрэг 11 дурсгалыг аймгийн хамгаалалтад оруулахаар үндэслэл саналыг боловсруулан холбогдох газарт хүргүүллээ.

Сумын 17 сургуулийн дотуур байранд амьдарч буй бага ангийн сурагчдын сурч хөгжих, орчныг сайжруулах зорилгоор хүүхдийн номын каталоги, ном сонгох зааврыг сургууль бүрд хүргүүлж, сургууль бүрийн сонгосон номын мэдээллийг нэгтгэж, хөгжлийн төвийн тоног төхөөрөмжийг аймгийн төвөөс сум хүргэх зардлын төсвийг тус тус Боловсролын чанарын шинэчлэл төсөлд хүргүүллээ.

Ерөнхий боловсролын сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлог хэрэгцээнд тохирсон боловсролын үйлчилгээний талаар 3 өрхийн эмч, 2 хүүхдийн эмч, эцэг эхийн холбооны 3 ажилтнуудад мэдээлэл өглөө.

Эрүүл мэндийн чиглэлээр: Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны А/14 дүгээр тушаалын дагуу хариуцлагатай 24 цагийн жижүүр ажиллаж, Эрүүл мэндийн газрын 70432526 утсанд COVID-19 сэжигтэй тохиолдол иргэдээс ирсэн дуудлагын мэдээлэл авах, холбогдох зөвлөгөө өгч мэдээллийг тухай бүрт нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлж байна.

Коронавирусын халдвараас сэргийлэх зорилгоор 3 дугаар сарын 2-10-ны өдрүүдэд УБ-хотоос автобусаар ирсэн иргэдэд утсаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласаны дээр аймгийн төвийн 5 хяналтын постын үйл ажиллагаатай танилцаж, постонд ажиллаж буй албан хаагчдад амны хаалт, сурталчилгааны материал, урьдчилан сэргийлэх заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

Шинэ төрлийн коронавирусын халдвар цар тахлын талаар Ховд, Олон ястан телевизүүд болон khovdnews.mn, khovdtimes.mn, newkhovd сайтуудаар дамжуулан “Коронавирусын халдвараас сэргийлэх” тухай 32 төрлийн, “Осол гэмтлээс сэргийлэх” тухай 4, давсны тухай 17, эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих 1 фото мэдээг тус тус түгээсэн. Цацагдсан шторкийн хувьд “Коронавирусын халдвараас сэргийлэх” 25, давсны 2, осол гэмтлийн 1 төрлийн мэдээлэл, сурталчилгаа явуулж 93636 иргэд мэдээлэл авсан байна.

Халдварт өвчний тархвар зүй тандалт судалгааны хүрээнд халдварт өвчний тандалтын мэдээг хам шинжээр 7 хоног болгон авч, EWAR программ дээр шивж, ХӨСҮТөвийн тандалтын албанд хүргүүлэв. Тандалтын мэдээгээр 3 сард цэврүүт халууралт тууралттай хам шинж 4, шарлалттай хам шинж 2, халууралт тууралттай хам шинж 3, суулгалт хам шинж 1 нийт халдварт өвчний 10 тохиолдол мэдээлэгдсэн байна. Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдээс 4 долоо хоногийн турш томуу, томуу төст өвчний мэдээг авч, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Томуугийн үндэсний төвд хугацаанд нь мэдээлж ажиллаа. Томуу, томуу төст өвчний цаг үеийн мэдээллийг бэлтгэн аймгийн Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, 23 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн хариу арга хэмжээг авч ажиллаж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн вируслогийн лабораторид хийгддэг томуу, томуу төст өвчний 3 дугаар сарын сорьцын шинжилгээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүүхдийн тасгийн амбулаториос 4 сорьц, Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвөөс 2 сорьц, Рашаант ӨЭМТөвөөс 1 сорьц, Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгээс 2 сорьц нийт 9 сорьц хүлээн авч, шинжилгээ хийхэд бүгд сөрөг гарсан.

Зэрэг сумын Хөндлөн багийн 5 настай эрэгтэй 3 сарын 5-нд халуурч, 3 сарын 7-нд Зэрэг сумын эрүүл мэндийн төвд үзүүлэн 3 дугаар сарын 9-нд БОЭТ-ийн халдвартын тасагт үзүүлж эмнэлзүйгээр Менингококкийн халдвар гэж оношлогдон хэвтүүлэн эмчиллээ

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанд Ховд сумын эрүүл мэндийн төвийн хөргөгч, аймгийн вакцины агуулахын хөргөгчийн хангалт дутмаг байгаа талаар мэдээлэл, албан тоот өгч нэг бүрийн үнэ 4,197,100 төгрөгийн өртөг бүхий Vestfrost VLS-064A маркийн мөсөн ханатай хөргөгч 3, дагалдах

хэрэгслийн хамт хүлээлгэн өгөөд байна мөн Халдварт өвчин судлалын үндэсний төвийн шуурхай удирдлагын нэгжийн ирүүлсэн зааврын дагуу, <https://docs.google.com/spreadsheets/> цахим хаягаар COVID-19 халдварын сэжигтэй тохиолдол, ажиглалтанд байгаа иргэдийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулж, ажиглалтанд авсан, гарсан иргэдийн мэдээллийг тогтмол мэдээлэн ажиллаж байна.

Шинэ төрлийн коронавирусын халдвар болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн “Шуурхай штаб”-аас байгууллага бүр гадна орчныхоо 50 метр талбайд тогтмол цэвэрлэгээ хийх, мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэл хийлгэх тухай үүрэг чиглэл өгсөн. Үүнтэй холбогдуулан 3-р сарын 13-ны өдөр Ард-Аюушийн талбай болон БОЭТ-ийн гадна талбай буюу нийт 10 мянга орчим мкв талбайд Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төв, Мал эмнэлгийн газар хамтран хлорын шохойн уусмалаар ариутгал халдваргүйтгэл хийж ажиллалаа.

Аймгийн Онцгой комиссын 16 дугаар хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2020 оны 03 сарын 16-18-ны өдрүүдэд Мэргэжлийн хяналтын газрын даргаар ахлуулсан Тагнуулын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Хилийн цэрэг, Гаалийн газар, Авто тээврийн төв, Зоонозын өвчин судлалын төв зэрэг байгууллагуудын алба хаагчдаас бүрдсэн ажлын хэсэг Хөшөөтийн уурхайн МоЭнКо ХХК болон тус уурхайд нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдийн нүүрс тээвэрлэлтийг “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”-д нийцүүлэн хэрхэн бэлэн байдлыг хангасан талаар хамтарсан хяналт шалгалтыг хийж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа. “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Булган боомт, МоЭнКо ХХК-д нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэж байгаа 22 аж ахуйн нэгж кемпийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтыг хийж, заавар, зөвлөгөө өгч, дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэв. МоЭнКо ХХК болон нүүрс тээвэрлэлтийг гэрээгээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд нь Монгол улсын Шадар сайд, Онцгой комиссын даргын баталсан “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”-ын шаардлагыг бүрэн хангаагүй, нүүрс тээвэрлэлт хийх нөхцөл бүрдээгүй байсан зөрчлүүдийг арилгах арга хэмжээг зохион байгуулан гүйцэтгэлийн хяналт шалгалтанд хамрагдаж, шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд тээвэрлэлт хийх нь зүйтэй гэж ажлын хэсэг үзлээ.

Онцгой байдлын ерөнхий газар болон Эрүүл мэндийн хөгжлийн төвд эрүүл мэндийн байгууллагуудын ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмж, хүчилтөрөгчийн хангамж, хамгаалах хувцас хэрэгсэл, эмийн нөөцийн хангамж, эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, халдваргүйтгэл, ариутгалын бодисын нөөц, тусгаарлах болон ажиглалтын өрөөнд байх эд зүйлсийн судалгааг гаргаж oyuntuya.ch.ot@gmail.com хаягаар хүргүүлж мэдээллээ. 3 дугаар сарын 11-ний өдөр

Булган сумын Булган боомтоор орж ирсэн 3 иргэнийг ажиглах байранд 14 хоног саатуулж, өдөрт 2-3 удаа эрүүл мэндийн үзлэг хийж, мэдээллийг өдөр бүр авч, холбогдох газруудад мэдээлэн ажиллаж байна.

БОЭТ, ЗӨСТ, Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, 0130-р ангийн эмнэлэг, МоЭнКо ХХК-ийн ЭММНЭД партнер эмнэлэг, Ач заяа зэрэг эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/135, А/153, А/93, А/101, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Монгол улсын хилээр орж ирж байгаа зорчигчдыг тусгаарлах, ажиглалтанд авах зөвлөмж, COVID-19 халдварын ажиглалтын үеийн тусгаарлан сэргийлэлт, авах арга хэмжээний зөвлөмж, COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх, халдваргүйжүүлэлт хийх зааварчилгаа, Зооноз өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны А/15 дугаар тушаал, Шадар сайд, улсын онцгой комиссын даргын баталсан COVID-19 үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журам, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам, ДЭМБ-ын хамгаалах хувцас хэрэгслийн хэрэглээний зөвлөмж зэрэг эрх зүйн акт, заавар, зөвлөмжийг цахим хаягаар албан тоотоор хүргүүлж арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх зааварчилгааг цахим хаягаар хүргүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдвартын тасгийн бэлэн байдлыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын ахлах байцаагчтай хамтран үзэж, одоогийн нөхцөл байдал цаашид авах арга хэмжээний талаарх асуудлыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн удирдлагууд, ажлын хэсгийнхэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллаа.

“Тэмбүүг устгая” үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс тэмбүүгийн эрт илрүүлэг, үзлэгийн 14 хоногийн мэдээг сард 2 удаа авч нэгтгэн ХӨСҮТ-ийн БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тандалт судалгааны албанд хүргүүлэн ажиллаж байна. 2020 оны 01 сарын 02-ноос 3 сарын 16-нийг хүртэл аймгийн хэмжээнд нийт ХДХВ-ийн шинжилгээнд 3294, тэмбүүгийн шинжилгээнд 3542 хүн хамрагдсан. 3 сарын 1-нээс 3 сарын 16-ний мэдээгээр ХДХВ-ийн шинжилгээнд нийт 651, тэмбүүгийн шинжилгээнд 708 хүн хамрагдаж 8 тэмбүү шинээр оношлогдсон. Он гарснаас хойш нийт 31 тэмбүү шинээр оношлогдсоноос 8 жирэмсэн тэмбүүтэй эх оношлогдсон байна. 1, 2-р сард оношлогдсон 23 хүнд тэмбүүгийн эмчилгээний 3 тунг авсан бөгөөд 3 сарын эхний 16 хоногт оношлогдсон 8 хүний эмчилгээ хийгдэж эхлээд байна.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээг 7 хоног бүр ХӨСҮТ-ийн medee@cpnd хаягаар мэдээлж ажилласан ба тайлант сард шинжилгээнд хамрагдсан хүний тоо 516, үүнээс С вирусын шинжилгээнд хамрагдсан хүн 496, В вирусын шинжилгээнд 511, үүнээс В эерэг гарсан 34, С эерэг гарсан 17, В вакцинд хамрагдсан 306 хүн байна.

Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдрийг угтан “Сүрьеэтэй тэмцэх үйл хэрэгт олон нийтийн анхаарлыг хандуулах, хүн бүрийн хүчин чармайлт чухал” гэдгийг сурталчилан таниулах зорилгоор “Амлалтаа биелүүлэх цаг нь боллоо! Арга хэмжээ авах цаг нь боллоо!” уриан дор Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн <http://ncph.gov.mn/> хаягнаас видео шторк, сурталчилгааны материал татан авч иргэдэд мэдээлэл түгээж ажиллахыг Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн газрын 279 дугаар албан тоотоор хүргүүлж 3 дугаар сарын сүүлийн долоо хоногт цахимаар сүрьеэ өвчнөөс сэргийлэх сурталчилгааг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Заавал хийх дархлаажуулалтад 0-2 насны хүүхдийг 99,5%-тай ХӨСҮТөвд мэдээлсэн ба газрын даргын 27 тоот албан бичгээр 2020 оны 2 дугаар улиралд хэрэглэгдэх заавал хийх дархлаажуулалтын захиалгыг дархлаажуулалтын албанд хүргүүлснээр хөргөгчний хэм хяналтын хэрэгсэл 33 ширхэг, хөргөгчний хэм тэмдэглэлийн дэвтэр 15 ширхэг, орлого зарлагын дэвтэр 50 ширхэг, 500 ширхэг сэргийлэх тарилгын гэрчилгээ болон нийт 16 нэр төрлийн вакцин түүнийг дагалдах хэрэгслийг хүлээн авч, анхан шатны нэгжүүдэд нийт 26 удаа вакцин, биобэлдмэл хүргүүлэв.

Шинэ коронавирусын халдвар дэгдэлттэй холбоотойгоор гарсан ЭМС-ын болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангуулах, явцын үнэлгээ хийх, короновируст халдвар (COVID-19)-ын дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлыг эрт сэрэмжлүүлэх, бэлэн байдлыг хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор аймгийн Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Буянт, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн, Мөст, Цэцэг, Манхан, Зэрэг, Дарви, Мөнххайрхан сумдад ажиллаж эх, барихын тусламж, хүүхдийн тусламж, чанар, гамшиг, эрсдэл, онцгой байдал, COVID-19-ийн бэлэн байдал, сувилахуйн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, эмийн чанар аюулгүй байдал чиглэлээр дэмжлэгт хяналт үнэлгээ хийж зөвлөмж өгч ажиллалаа.

Мөн COVID-19 халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын санаачлагаар аймгийн төвийн Ачит-алтан хундага, Ховд Монос, Вансэмбэрүү эмийн сангуудтай хамтран “ANTI-COVID-19” аян өрнүүллээ. Аяны хүрээнд шүүхийн байгууллага, БСУГ, Нийгмийн даатгалын хэлтэс, Мобиком зэрэг иргэдийн бөөгнөрөл ихээр бий болдог 6 байгууллагын 16 гаруй өрөө тасалгаанд нян устгах гэрлээ зөөвөрлөн ажиллууллаа

Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлгээр тайлант сард сумдын эрүүл мэндийн төвүүдэд өссөн дүнгээр нийт 1212578,3 мянган төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 263548,5 мянган төгрөгийн санхүүжилтийг тавьж олголоо.

Тав: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар: Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.1.2-д заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын

газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг бичиж, Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үнэлгээний дүнг нэгтгэн гаргав. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үнэлгээний дүн 2019 оны жилийн эцсийн байдлаар 94.0 хувийн хэрэгжилттэй байна. Журмын дагуу 7 бүлэг тайлангийн үнэлгээг тус бүрд нь товчоолон, дүгнэлт хийж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хавсралтаар гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Үүнд:

1. Засгийн газрын гишүүн, сайд нараас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан


Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Засгийн газрын гишүүн 14 яамны сайд нараас аймгийн Засаг даргатай 513 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх болон хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан байна. Засгийн газрын гишүүдтэй аймгийн Засаг дарга 2019 онд байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлэхэд 93.2 хувийн биелэлттэй дүгнэгдлээ.

Монгол улсын Засгийн газрын гишүүн, сайд нараас Ховд аймгийн Засаг даргатай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх болон хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Д/д	Гэрээ	Арга хэмжээ -ний тоо	Үнэлгээ					Нийт оноо	Үнэлгээ /хувиар/	Оноо	Үнэлгээ	
			Арга хэмжээ хүтцээ	Боловс хамгаара лгүй	0	30	70					100
1	Монгол Улсын Шадар сайд	28			2	1	4	21	2410	86.1	4.3	В
2	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга	20					1	19	1970	98.5	4.92	А
3	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	31				1	1	29	3000	96.8	4.84	А
4	Сангийн сайд	24					3	21	2310	96.3	4.81	А
5	Хууль зүй, дотоод хэргийн сайд	23		2	1	2	4	14	1740	82.8	4.14	В
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	51					12	39	4740	92.9	4.64	А
7	Батлан хамгаалахын сайд	28					5	23	2650	94.6	4.73	А
8	Барилга хот байгуулалтын сайд	67	1		2	1	4	59	6210	92.7	4.63	А
9	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	82				1	13	68	7740	94.4	4.72	А

10	Зам, тээврийн хөгжлийн сайд	33				1	3	29	3140	95.2	4.76	A
11	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	21		2		1	3	15	1740	92.0	4.6	A
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	35					11	24	3170	90.6	4.53	A
13	Эрчим хүчний сайд	12					2	10	1140	95.0	4.75	A
14	Эрүүл мэндийн сайд	58					9	49	5430	95.3	4.76	A
Дүн		513	1	4	5	8	75	420	47390	93.2	4.66	A

Монгол улсын Засгийн газрын гишүүн, сайд нараас Ховд аймгийн Засаг даргатай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх болон хамтран ажиллах гэрээний биелэлт (2019 оны жилийн эцсийн байдлаар)



Засгийн газрын гишүүн, 14 яамны сайд нар Ховд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан 513 хөтөлбөр, арга хэмжээний 81.7 хувь буюу 419 заалт бүрэн хэрэгжиж, 14.8 хувь буюу 76 заалт “хэрэгжих шатанд”-аа 70 хувьтай, 1.6 хувь буюу 8 заалт “хэрэгжилт хангалтгүй”, 30 хувьтай хэрэгжсэн ба үлдсэн 1.9 хувь буюу 10 хөтөлбөр, арга хэмжээнээс 5 заалт орон нутгаас шалтгаалахгүй үнэлэх боломжгүй, 1 заалт хугацаа болоогүй, 4 заалт “хэрэгжээгүй” буюу 0 хувьтай байна. Тасарсан болон бүрэн хэрэгжээгүй 13 хөтөлбөр, арга хэмжээ нь төсөв санхүүгийн асуудал шийдэгдээгүй, дээд шатны байгууллагад уламжилсан боловч хариу ирүүлээгүй, зохион байгуулалт муутай зэрэг асуудлаас шалтгаалан бүрэн хэрэгжээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, сайд нараас Ховд аймгийн Засаг даргатай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх болон хамтран ажиллах гэрээ, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн

эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн гол зорилтуудаа тодорхойлж, иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгоход анхаарч аймгийн ИТХ-аас 2019 оныг “Өрхийн болон жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарлаж, олон ястан, үндэстний өлгий Ховд нутгийн бүтээлч ард иргэд, аж ахуйн нэгжүүд УИХ, Засгийн газар, яам агентлаг, олон улсын төсөл, хөтөлбөрийн газруудтай хамтран ажиллаж, хөгжилд хөтөлсөн олон арван төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.

Түүнчлэн дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 29 дэд хөтөлбөр боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд эдгээрийн үр дүнд аймгийн эдийн засаг, нийгэм, соёл, спорт, боловсрол, эрүүл мэнд, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын салбарт томоохон ахиц гарсан жил боллоо.

2. Ховд аймгийн 2019 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайлан

Улсын болон орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой болгох, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүллээ.

Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх зарчимд суурилсан Шилэн дансны тухай хуулийг төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналттай холбоотой мөнгөн болон бусад гүйлгээг хамруулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2019 оны төсвийн жилд санхүү, төсвийн холбогдолтой хууль, журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг сайжруулах, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, шилэн дансны хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Санхүүгийн үйл ажиллагааны хөтөч” календар

боловсруулан хэвлүүлж, төсөвт байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд дээрх зорилтын хүрээнд 2019 оны жилийн эхнээс аймгийн хэмжээнд “Теле маркетинг” үйлчилгээ нэвтрүүлж, төсвийн захирагч, нягтлан бодогч 230 гаруй хүнд сар бүр мессежээр чиглэл хүргүүлж, шилэн дансны мэдээллийг бүрэн, хугацаандаа оруулахыг анхааруулж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Хуулийн хэрэгжилтийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн Дотоод хяналтын ажилтан хариуцаж, сар, улирал бүр хяналт тавьж, хугацаандаа мэдээллээ оруулаагүй болон хугацаа хоцроосон төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт мэдээллээ нөхөж бүрэн оруулах талаар заавар, зөвлөмж хүргүүлэн алдааг засуулж, хариуцлага тооцуулахаар аймгийн Засаг даргын А/774 дүгээр захирамж гаргаж, мэдээллээ

хугацаандаа бүрэн оруулаагүй 7 албан тушаалтанд сануулах, 4 сумын Засаг дарга, 1 байгууллагын даргад хариуцлага тооцож, ажилласан байна. Дээрх үйл ажиллагаа, арга хэмжээний үр дүнд шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь оруулж байгаа нь хуулийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэхэд нөлөөлөхүйц ажил боллоо.

2019 оны 12 дүгээр сарын 31-ний байдлаар аймгийн хэмжээнд нийт 17 сум, 162 албан байгууллагын 23576 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 23411 мэдээлэл байршуулж, нийт байршуулсан 23411 мэдээллийн 19345 мэдээллийг хуулийн хугацаанд, 4066 мэдээллийг хугацаа хоцруулан оруулсан байна. Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн албан бичигт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар 2020 оны 01 дүгээр сарын 16-ны байдлаар тайлан гаргалт 100 хувийн биелэлтэй байна гэж дүгнэсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулсан байдал (өссөн дүнгээр)

Улирал	Мэдээлэл оруулах байгууллагын тоо	Байгууллагуудын нийт оруулах мэдээллийн тоо	Мэдээллээ бүрэн оруулж тайлан илгээсэн	Мэдээллийг хуулийн хугацаанд аа оруулсан	Мэдээллийг хуулийн хугацаа хоцорсон	Үнэлгээ
1	162	7001	7271	5369	1902	100
2	162	12526	12653	9979	2674	100
3	162	18051	18058	14632	3426	100
4	162	23576	23411	19345	4066	99.3
Дундаж үнэлгээ						99.8

Төвлөрүүлэн захирагч нарын шилэн дансны мэдээлэл байршуулсан дундаж үзүүлэлт 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 95.6 хувьтай, төсөвт байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилт, мэдээлэл оруулсан үзүүлэлт дунджаар 100 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шилэн дансны мэдээлэл оруулсан байдал дунджаар 97.9 хувьтай байгаа бөгөөд үүнээс Ховд суварга 72.0 хувь, Шим-Ус ОНӨҮГ 77.0 хувьтай шилэн дансны мэдээлэл оруулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын шилэн дансны мэдээллээ оруулсан дундаж үзүүлэлт 95.6 хувьтай байна.

Төвлөрүүлэн захирагч нарын шилэн дансны мэдээллийг ил тод мэдээлсэн дундаж үзүүлэлт 95.6 хувьтай байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 20 хувиар өссөн дүнтэй гарлаа.

Төсөвт байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилт 100 хувьтай байгаа нь өмнөх жилийнхээс 22.1 хувиар өссөн үзүүлэлт гарч энэ нь төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч нарын төсвийн талаарх мэдээллээ хугацаандаа мэдээлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласны үр дүн юм.

Орон нутгийн төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээлэл оруулсан байдал (2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Төсвийн төрөл	Сумын нэр	Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Хугацаанд нь оруулсан	Хоцорсон	Гүйцэтгэл
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	Алтай сум	1013	1042	644	398	100%
2		Булган сум	1158	1133	988	145	97.8%
3		Буянт сум	870	877	750	127	100%
4		Дарви сум	870	904	669	235	100%
5		Дуут сум	870	876	791	85	100%
6		Зэрэг сум	1156	1142	962	180	98.8%
7		Манхан сум	1015	1015	897	118	100%
8		Дөргөн сум	870	890	633	257	100%
9		Мянгад сум	1013	1053	917	136	100%
10		Мөст сум	725	727	642	85	100%
11		Мөнххайрхан сум	870	879	855	24	100%
12		Үенч сум	870	906	624	282	100%
13		Ховд сум	870	876	803	73	100%
14		Цэцэг сум	870	829	714	115	95.3%
15		Чандмань сум	870	890	652	238	100%
16		Эрдэнэбүрэн сум	870	824	764	60	94.7%
17		Жаргалант сум	3769	3693	3439	254	98%
ДҮН			18549	18556	15744	2812	99.9

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын шилэн дансны мэдээлэл оруулсан байдал

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлэл оруулах	Мэдээлэл оруулсан	Хугацаанд	Хоцорсон	Гүйцэтгэл
1	Ховд Мянган Угалзат ОНӨҮГ	131	118	85	33	90%
2	Ховд суварга ОНӨААТҮГ	131	94	43	51	72%

3	Ховд Шим-Ус ХХК	132	102	60	42	77%
4	Ховд аймаг Мянгад сум Шим-Ус ОНӨААТҮГ	131	131	88	43	100%
5	Минжит булган хот тохижилт ОНӨААТҮГ	131	131	67	64	100%
6	Тээлийн илч ОНӨААТҮГ	131	131	81	50	100%
7	Зэрэг шим ус ОНӨААТҮГ	131	127	54	73	97%
Дүн		918	834	478	356	90.85

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулахад хоосон мэдээлэлд “0” утга тавихгүй тохиолдолд оруулаагүй, засвар хийхэд хугацаа нь тухайн өдрөөр болж өөрчлөгдөж байгаа нь учир дутагдалтай хэвээр байна.

Тухайн байгууллагад хөрөнгө оруулалтын чиглэлээр мэдээлэл байхгүй бол заавал мэдээлэл байрших хэсэгт орж “0” утга тавин баталгаажуулах нь илүүц бөгөөд улирал бүрээр тайлан илгээх эрхийг төсвийн шууд захирагч нарт байгаа нь төвлөрсөн бус, хяналт сул, нэгдсэн бодлого алдагдаж байна.

Түүнчлэн шилэн дансны мэдээллийг ашиглах хэрэглэгч цөөн, мэдээлэл оруулахад гар ажиллагаа ихтэй бөгөөд программ үе үе саатдаг явдал нь цахим хуудсанд мэдээлэл оруулахад хүндрэл учруулж, 2019 оны 1, 2, 3, 4 дүгээр сард хуулийн хугацаандаа шилэн дансны мэдээллээ оруулах гэхээр системд нэвтэрч чадахгүй хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж, мэдээлэл оруулах идэвх суларсан.

Үүний зэрэгцээ улирал бүрээр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайлангаар илэрсэн зөрчлийг арилгуулж, хариуцлага тооцож ажилласнаар ажил сайжирч, үр дүн нэмэгдэж байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд сар, улирал, хагас бүтэн жилийн мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь байршуулахад дээрх гарч буй дутагдлуудад анхаарах хандуулах хэрэгтэй байна.

3. Аймгийн ИТХ-ын болон ИТХТ-ийн тогтоолоор баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулсан 29 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагналаа.

Аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн (салбар тус бүрээр)

№	Салбараар	Хөтөл- бөрий н тоо	Зорилт- ын тоо	х болгом	Үнэлгээ				Нийт	Үнэлг ээ хуви
					0	40	70	100		

										ар
1	Төрийн байгуулалтын чиглэлээр	1	2					2	200	100
2	Эрүүл мэндийн чиглэлээр	4	17				3	14	1610	94.7
3	Боловсрол, соёл, спортын чиглэлээр	7	28					28	2800	100
4	Хууль, эрх зүйн чиглэлээр	3	13				3	10	1210	93.1
5	Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр	4	20				4	16	1880	94.0
6	Хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр	4	19				2	17	1840	96.8
7	Санхүүгийн чиглэлээр	1	3					3	300	100
8	Гэр бүр, хүүхэд залуучууд, нийгмийн халамж, үйлчилгээний чиглэлээр	5	18				4	14	1680	93.3
Нэгдсэн дүн		29	120				16	104	11520	96.0

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан 29 дэд хөтөлбөрийн 120 зорилтоос “үр дүнтэй” буюу 100 хувьтай биелсэн 104 зорилт, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувийн биелэлттэй 16 зорилт, дунджаар 96.0 хувьтай хэрэгжсэн байна.

Эндээс үзэхэд аймгийн 29 дэд хөтөлбөрийн 48.3 хувь буюу 14 дэд хөтөлбөр “Үр дүнтэй” буюу 100 хувьтай, 51.7 хувь буюу 15 дэд хөтөлбөр 90.0-96.0 хувийн биелэлттэй, дунджаар 96.0 хувьтай “А” үнэлгээтэй дүгнэгдсэн нь аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтууд үр дүнтэй хэрэгжсэн болохыг харуулж байна.

4. Аймгийн ЗДҮАХ-ийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ тайлан

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 84 зорилтын 354 арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2020 оны 2 дугаар сарын 15-ны байдлаар дунджаар 91,3 хувийн биелэлттэй тооцогдсон байна.

Хөтөлбөрт тусгагдсан 354 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг салбар тус бүрээр нь товч танилцуулбал:

- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 36 зорилтын 130 арга хэмжээний биелэлтийг тооцоход үнэлгээний дундаж 90,0 хувьтай үнэлэгдсэн байна.

- Нийгмийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 19 зорилтын 124 арга хэмжээний биелэлтийг тооцоход үнэлгээний дундаж 93,8 хувьтай үнэлэгдсэн байна.

- Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 8 зорилтын 23 арга хэмжээний биелэлтийг тооцоход үнэлгээний дундаж 96,1 хувьтай үнэлэгдсэн байна.

- Засаглалын бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 21 зорилтын 77 арга хэмжээний биелэлтийг тооцоход үнэлгээний дундаж 88,1 хувьтай үнэлэгдсэн байна.

Нийт арга хэмжээний биелэлтийг тооцож хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд “үр дүнтэй” буюу 100 хувийн үнэлгээтэй 252 арга хэмжээ, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувийн үнэлгээтэй 82 арга хэмжээ, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн үнэлгээтэй 5 арга хэмжээ, “үр дүнгүй” буюу 0 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 13 арга хэмжээ байгаа ба үнэлгээний дундаж 91,3 хувьтай үнэлэгдсэн байна.

2016-2020 онд хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад 2020 оны 2 дугаар сарын 15-ны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээс харахад “Үнэлэх боломжгүй” 13 арга хэмжээ байгаа нь орон нутгаас үл хамаарсан, гадаад хүчин зүйлээс хамааралтай эсвэл төсөв хөрөнгө олгогдоогүйгээс тасалдаж буй арга хэмжээ юм.

5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайлан

Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны “Удирдамж, үзүүлэлт батлах тухай” 302 дугаар тушаалаар 16 төрлийн 32 шалгуур үзүүлэлт бүхий аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт батлагдсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 2019 онд дунджаар 96,1 хувийн үнэлгээтэй байна. Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар тооцож байгаа тул зарим статистик тоо баримтууд эцэслэн гараагүй бөгөөд урьдчилсан байдлаар тооцсон болно.

6. “Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан” болон “Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт”-ийг журмын 9, 10 дугаар хавсралтын дагуу гаргаж тайлагналаа.

Түүнчлэн Н.Баасанжавын нэрэмжит Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу БОЭТ-ийн “Дотоод хяналт-шалгалт, дотоод аудит”-ын багынханд зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2017 оны А/347 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол

шийдвэрийн хэрэгжилт, захиргааны болон төсвийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын талаар сургалт зохион байгуулав.

Сургалтаар бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахад анхаарах асуудал, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн биелэлт тооцох, тайлагнах талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Мөн аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулсан удирдамжийн дагуу “Ховд аймгийн төрийн байгууллагуудын цахим мэдээлэл ба ил тод байдлын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамж”-ийн дагуу 17 сум, 34 албан байгууллагын цахим хуудсанд үнэлгээ хийж байна.

“Соёлтой төрийн үйлчилгээ-Авлига хүнд сурталгүй аймаг” болох зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг сайжруулах зорилгоор төрийн байгууллагуудын цахим хуудсанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, 2017 оны 89 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралтаар баталсан ил тод байдлын шалгуур үзүүлэлт, “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гүйцэтгэж байна.

Зургаа: Сумдын мэдээлэл:

Зэрэг сум: Вирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран ЗДТГ-ын албан хаагчид, ЭМТ-ийн албан хаагчдаас 5 ажлын хэсгийг тавьтын системээр зохион байгуулан гаргаж 15 дэлгүүр, үйлчилгээний төвүүд, 9 албан байгууллага, 173 айл өрх, хашаанд ариутгал халдваргүйтгэлийг 3 дугаар сарын 9-10 өдрүүдэд хийлээ. Энэ үеэр хлорын шохой 62,5 кг, жавелион 785 ширхэгийг (жавелион 5ш*1500 төгрөг, хлорын шохой 1кг*5000 төгрөг) зарцуулж нийт 548,500 төгрөгийн зардал гарсан. Албан байгууллага, үйлчилгээний төвүүд, айл өрхөд ариутгал халдваргүйтгэлийн бодис нөөцөд олгож, хэрэглэх заавар, Ковид-19 үеийн зөвлөмжүүдийг тарааж ажиллав.

Сумын Эрүүл мэндийн төвд комбинзон 10ш, хлорын шохой 125 кг, жавелион 2800 ш, автоматик 2ш, халууны шил 5ш, гар ариутгагч 10ш, маск 120 ширхэгийг тус тус нөөцөлж, бэлэн байдлыг хангаад байна.

Сумын “Эмэгтэйчүүдийн зөвлөл”, “Амгалан шаглаа” оёдлын цехийн хамт олон 220ш, иргэн Г.Мөнхтулга 50ш амны хаалтыг Эрүүл мэндийн төвд хүлээлгэн өглөө. ЭМС-ын 135 дугаар тушаалаар ЭМТ-ийн эмч мэргэжилтнүүд ажилчдад хамгаалах хувцас хэрэгслийг өмсөж тайлах дарааллаар 2 удаагийн сургалт арга хэмжээг зохион байгууллаа.

COVID-19 халдварын үеийн эмнэлгийн түргэн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, эрсдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх талаар Засгийн газар, ЭМЯ, УОК, аймгийн онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж сумын Эрүүл мэндийн төв нь халдварын үеийн бэлэн байдлын төлөвлөлт хийж, шуурхай арга хэмжээний 2 баг томилон 3 өрөөнд 10 ор дэлгэн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Сургууль, цэцэрлэг нь БСШУС-ын яамнаас зохион байгуулж буй теле хичээлийн хуваарийг эцэг эхчүүддээ цахим хуудас болон утас ашиглан дамжуулж тухайн хичээлтэй холбоотой нэмэлт мэдээллүүдийг багш нар групп чат ашиглан хүргэж эргэх холбоотой ажиллаж байна. Теле хичээлд цэцэрлэгийн насны нийт 198 хүүхдээс 167 хүүхэд хамрагдаад байгаа бөгөөд энэхүү мэдээллийг 7 хоног бүрийн Пүрэв гаригт аймгийн БСУГ-т хүргүүлж байна.

Буянт сум: Сумын Засаг даргын 2020 оны А/21 тоот захирамжаар сумаас аймаг, хот хооронд, бусад сумдад гарах, орох автомашины хөдөлгөөнийг хязгаарлаж, хяналтын постыг Буянт голын гүүрний хажууд гаргаж, постод 24 цагаар төрийн 25 албан хаагч 6 ээлжээр ажиллав. Энэ хугацаанд Ховд аймаг болон Баян-өлгий аймаг, Улаанбаатар хот, хөшөөтийн уурхайгаас постоор 92 тээврийн хэрэгсэл, 226 иргэн дамжин нэвтэрсэн. Эдгээр тээврийн хэрэгсэл Хүнс хүргэх, өвс тэжээл ачих, ар гэрийн гачигдал, эмнэлгийн түргэн тусламж, эм эмнэлгийн хэрэгсэл хүргэх, албан томилолт зэрэг шалтгаанаар Буянт, Дөргөн, мянгад сумд, Увс, Завхан, Архангай зэрэг аймгууд орохоор дамжин өнгөрсөн, зорчигчдын халууныг Эрүүл мэндийн төвийн эмч нар үзэхэд, ямар нэг сэжигтэй тохиолдол илрээгүй болно. Мэдээг тухай бүр аймгийн Онцгой байдлын газарт мэдээлж ажилласан.

Манхан сум: Аймгийн Онцгой комиссын хурлын 2020 оны 02 тоот шийдвэр, МХГ-ын даргын 2020 оны 40 тоот албан бичгийн дагуу удирдамж боловсруулан дэлгүүр, цайны газар, зоогийн газар, фермерийн аж ахуйн үйл ажиллагаанд ариутгал халдваргүйжүүлэлт хийж зөвлөмж хүргүүлэн ажиллалаа. Тахилт багийн нутаг дэвсгэрт байрладаг “Бор үхэрт”, Төгрөг гол багийн нутаг дэвсгэрт байрлах “Сэнхэр агуйт” ХХК-ны үхрийн аж ахуйд ариутгал халдваргүйжүүлэлт хийж зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Сумын онцгой комисс 3 удаа хуралдаж холбогдох байгууллагын удирдлагуудад үүрэг чиглэл өгч ажиллав.

Дарви сум: Сумын хүн эмнэлэг тайлант сард нийт 416 хүн үзэж, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж ажиллав. Эрүүл мэндийн сайдын 08 дугаар албан даалгаврын дагуу томуу болоод хэвтэн эмчлүүлэгчдийн мэдээг долоо хоног бүрийн нэг дэхь өдөр аймгийн Эрүүл мэндийн газарт мэдээлж байна. Төлөвлөгөөний дагуу сумын Засаг даргын Тамгын газартай хамтран ААН болон айл өрхүүдэд коронавирусын талаар зөвлөмж, 276 иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

Жаргалант сум: “Тайван амгалан Ховдчууд”, “Хариуцлагатай Тунгалаг төр” хөтөлбөрүүдийг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа.

Covid-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Жаргалант сумын нийтийн орон сууцны 11 СӨХ-дод ариутгал халваргүйжилт хийх үүрэг чиглэл өгч цэнхэр спирт 10 летр, ариутгалын бодис 1000гр, резинэн бээлий 60 ширхэг, даавуун бээлий 120 ширхэг, амны хаалт 200 ширхэгийг өгч үйл ажиллагаанд нь Захирагчийн ажлын алба хяналт тавьж ажиллалаа.

Жаргалант сумын ЗДТГ-аас “Орцоо цэвэрлье” уриалга, challenge эхлүүлж 5 байрны 92 айл өрх хамрагдаж орцоо ариутгаж халдваргүйжүүлээ. Цаашид тус арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөөд байна. Covid-19 вирусын халдварын хорио цээрийн дэглэмтэй үед иргэдэд хууль эрх зүйн мэдээ мэдээллийг “Жаргалант сумын ИТХ, ЗДТГ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл” page хуудсаар дамжуулан иргэдэд сурталчлан мэдээлж байна.

Сумын Мал эмнэлэгийн тасаг нь шөвөг яр, цусан халдвартын вакцинийг татан авч хүрэн хошуу МЭҮН, Харзны эх МЭҮ нэгжүүдэд хүлээлгэн өгч халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулаад байна. Манай сумын хэмжээнд 45683 мал төллөхөөс гүү 152, үнээ1533, ингэ10, эм хонь14541, эм ямаа 20589, нийт 36825 мал төллөж 28 төл хоргодоод байна. Том малын зүй бус хоргодолоор 81 мал хоргодоод байна.

Коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газартай хамтран мал аж ахуй, туслах аж ахуй эрхлэдэг 8 фермерүүдийг Хайкоф, Хлорын шохойгоор ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Худаг усан хангамж” сарын аяныг зохион байгуулж сумын Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу сумын хэмжээнд иргэдэд ундны ус түгээж буй худгуудад ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг аймгийн Мал эмнэлэгийн газар, Зооноз өвчин судлалын төвтэй хамтран сумын хэмжээнд ундны ус түгээж буй 42 худгийн барилга, дотор гадна нийт 840 м² талбайд 0,3 процентийн жавелионы уусмалаар ариутгал халдваргүйжүүлэлт хийв.

Сумын Засаг даргын 2020 оны А/69 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж албан байгууллага, аж ахуйн нэгж нь өөрийн эзэмшил болон ойр орчмын 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын Ойн анги, Хар ус нуурын БЦГ-ын захиргаатай хамтран Шим ус-ны харьяа цэвэр усны таван худгийн эргэн тойрны болон Буянт гол дагуу хог хаягдлыг цэвэрлэж, нийт 3 машин хур хогийг хогийн цэгт буулгав. Буянт гол дагуу 17 ширхэг бие засах газар, хогийн букер 2 ширхэг усанд автагдсаныг буулгаж нүхийг цэвэр шороогоор булж ариутгав.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар багуудын Засаг дарга нартай хамтран хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж нийтийн эзэмшлийн гудамж талбайд бохир ус асгасан, ил задгай хог хаягдал хаясан зөрчил илэрч зөрчил гаргагчдад зөрчил арилгуулах талаар мэдэгдэх хуудас өгч зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллалаа.

Аймгийн “Бадамлах дөл” ХХК-ны дулааны станцын төв дамжуулах шугам сүлжээг шинэчлэх төсөл 2019 онд хэрэгжих явцад нийтийн эзэмшлийн тохижилттой талбай, явган хүний зам, авто замын саад хашлагуудын хэвийн байдлыг алдагдуулсан тул буцаан сэргээж засварлах, шинэчлэх хэвийн байдалд оруулах талаар 21-04-340/02 тоот улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Алдарт эхийн 1 дүгээр одонгоор 10, 2 дугаар одонгоор 100, нийт 110 эхийн баримт бичгийг хуулийн дагуу бүрдүүлж аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүллээ. Сургууль, цэцэрлэгийн ариутгал хийх ажлыг зохион байгуулах талаар Эрүүл мэндийн газар, Зооноз өвчин судлалын төвд албан бичиг хүргүүлж сургууль, цэцэрлэгийн 80 хувь нь ариутгал халдваргүйжилтийн ажлыг зохион байгуулсан.

Сумын бүтэн өнчин -33, хагас өнчин -611, өрх толгойлсон 1564, хөгжлийн бэрхшээлтэй 986, ахмад настан 2895 иргэн, ажилгүй 4447 иргэний судалгааг 12 багийн нийгмийн ажилтан, статистик хариуцсан мэргэжилтэн хамтран нэгтгэж гаргав. Сумын 2-5 насны 3958, 6-18 насны 7351 хүүхдийн судалгааг шинэчлэн гаргав.

Дэлхийн Зөн Ховд ОНХХ-ийн газартай хамтран ажиллаж 150 өрхөд нүүрс, хүнсний тусламж олгосон. Мөн дахин 110 өрхөд хүнсний тусламж өгөхөөр ажлын хэсэг байгуулан айл, өрхийн судалгааг хийж байна. Сумын хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд Алагтолгой -2, Наран -1, Цамбагарав -1, Буянт багт 1 нийт 5 өрхийг хамруулан ажилласан.

Covid-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Олон нийтийн эргүүл хийж Засаг даргын орлогчоор ахлуулсан, нийгмийн бодлогын мэргэжилтэн, 12 багийн нийгмийн ажилтан нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй 4 ажлын хэсэг ажиллав. Тус ажлын хүрээнд Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулиуд, эмийн сан, спорт заал, РС тоглоомын газар, биллярд, мөрийтэй тоглоомын газруудаар үйл ажиллагааны талаарх хяналт тандалтыг хийж, эмийн сангуудаас амны хаалт болон ариутгал халдваргүйжүүлэлтийн нөөц бүрдүүлэлт, үнийн судалгааг хийж ажиллав.

Дөргөн сум: Сумын онцгой комиссын 2020 оны 06 тоот хурлын шийдвэрээр сумаас гарах зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 08:00 цагаас 03 дугаар сарын 16-ны өдрийн 08:00 цаг хүртэл түр зогсоох шийдвэрээр Улаан хаг, Баян-Овоо, Төгий, Шандас хэмээх газруудад хяналтын постыг ажиллуулж, пост тус бүрд 4 төрийн албан хаагчийг томилж ажиллууллаа. Мөн 03 сарын 11-ний өдрөөс 03 сарын 16-ны өдрүүдэд шуурхай жижүүр, шуурхай дуудлага хүлээн авах дугаар ажилуулан, ард иргэдэд коронавирусын талаар мэдээлэл өгч, амны хаалт хэрэглэхийг зөвлөж, хяналт тавин, мэдээг цаг тутамд холбогдох газарт хүргүүлэн ажиллав.

Худалдаа үйлчилгээ үзүүлдэг хүнсний дэлгүүрүүдийн худалдан борлуулж байгаа хүнсний бүтээгдэхүүн, мах, хүнсний ногоо, жимс жимсгэний гарал үүсэлд хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн эрүүл мэндийн байгууллага хамтран 7 хоног бүр тогтмол хяналт тавьж, бараа, бүтээгдэхүүн татахдаа гарал үүслийн

гэрчилгээтэй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн худалдан борлуулахыг зөвлөж зөвлөмж хүргүүлэн ажилласан.

Сумын Засаг даргын захирамжаар 03 сарын 17-ноос эхлэн архи согтууруулах ундааг худалдан борлуулахыг хориглож, захирамжийн хэрэгжилтэнд хэсгийн төлөөлөгч, цагдаа, олон нийтийн байцаагч нар хяналт тавин ажиллаж байна.

2020 оны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд колибактериоз өвчний хүрээнд 1160 малыг вакцинжуулалтанд хамруулсан. Хөдөөгийн багуудад 860 м² талбайд хлорын шохойн 2%-ийн уусмалаар 82.000 төгрөгийн зардал гаргаж ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Малын мах 2444кг, 7 адуунд цахимаар гарал үүслийн гэрчилгээ олгосон, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд үхэр 17, ямаа 245, тэмээ 31 нийт 293 малыг боловсруулалтанд хамруулсан.

Тэтгэврийн даатгалын сангаас тайлант сард нийт 386 тэтгэвэр авагчдад 136105.9 мянган төгрөгийн санхүүжилтээр тэтгэвэр бүрэн тавьж олгосон. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 283, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч-32, 71 иргэнд тахир дутуугийн тэтгэвэр олгож, 3 хүнд шинээр өндөр насны тэтгэвэр тогтоосон. Сайн дурын даатгалд нийт 59 даатгуулагчийн 3044.6 мянган төгрөг, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 2009.6 мянган төгрөгийн шимтгэлийн орлого тус тус төвлөрүүлж, эрүүл мэндийн даатгалд 7 даатгуулагчийн 117.6 мянган төгрөгийн орлого орууллаа. Тэтгэмжийн даатгалын сангаас 1 хүнд оршуулгын тэтгэмж 1000.0 сая төгрөг тус тус олгов.

Сумын амьжиргааг дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж, хуралдаанаар бүлгийн төсөлд хамрагдах бүлгийг сонгох, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настанд асаргааны тэтгэмж тогтоолгох зэрэг асуудлыг хэлэлцэж, холбогдох баримт бичгийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүллээ.

Нийгмийн халамжийн тэтгэврийг 35 хүнд 6090,000, ахмад настны асаргааны тэтгэмж 50 иргэнд 3800000, ХБИ-ий асаргааны тэтгэмж 18 иргэнд 1368000, хүүхэд асаргааны тэтгэмж 145 эхэд 7250000, жирэмсэн эхийн тэтгэмжийг 32 эхэд 1280000 төгрөгийг тус тус олгууллаа. Хүнсний эрхийн бичгээр үйлчлүүлдэг 42 өрхөд 2020 оны 3 дугаар сарын 3048000 төгрөгийн хүнсний барааг олгов. Хүүхдийг мөнгө нь орохгүй байгаа 8 хүүхдийн судалгааг илгээж бүртгэлд орууллаа. Сумын харьяалалгүй 184 ахмадын хүндэтгэлийн мөнгийг программд шивж, нэрийн дансаар нь 1840000 төгрөгийг олгуулсан. Цалинтай ээжийн тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэлтэй давхацсан 10 эхтэй уулзаж ярилцан давхардлыг арилгах арга хэмжээ авч, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хөтөлбөрт хамрагдаад эргэн төлөлтөө хугацаандаа хийгээгүй 10 иргэнд мэдэгдэх хуудас өгч ажиллав.

Сумын Эрүүл мэндийн төв амбулатороор 174, нийт дуудлага-21 алсын дуудлага 17, ойрын дуудлага 4 удаа явж 14 иргэнийг хэвтүүлэн эмчиллээ. Эх хүүхдийн ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 4 эхийг БОЭТ-д шилжүүлж, нийт 49 эхийг жирэмсний хяналтанд авч ажиллав.

Эрдэнэбүрэн сум: Тайлант сард дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шураг багийн Засаг дарга санаачлан багийн иргэдээ уриалж Баруун элсний амны гол дээр 1,8 диаметр бүхий 2м урт 8ш бетонон кольцог хооронд нь бэхэлж мал гаргах гүүр барих боломж бүрдүүлээ.

2. Ховд голоос хиймэл нуур луу ус салгадаг боолт даланг засварлан сэргээснээр 49 га талбайг байнгын устай байлгах нөхцөл бүрдлээ. Энэ ажлын шатахууны зардалд байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 1100.0 мянган төгрөг, үйлчилгээний хөлсөнд 6 ногоочин 2080.0 төгрөг бүгд 3180.0 мянган төгрөг зарцууллаа.

3. Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, Цамбагарав уулын Тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч, ЗДТГ-ын байгаль орчны албаны мэргэжилтэн, байгаль хамгаалагчид байгалийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор морьтой өвөлжөө, зуслангийн бүс нутгаар явж бугын ажиглалт хийв. Ажиглалтаар 20-30 буга Баянгол багийн нутагт байршилтай байгааг олж мэдээлэв.

4. Коронавирусын халдвар, эрсдэлээс сэргийлэх, хамгаалах зорилгоор босоо тэнхлэгийн авто зам дээр аймаг, сумаас хамтарч гарах хяналтын постыг 2020.03.10-ны өдрөөс Хашаатын аманд байршуулан хүнс, шатахууны дэмжлэг үзүүлэв.

5. Сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг, гэр хороололд жишиг хороолол байгуулах ажлын тендер шалгаруулалтыг зарлаж, Намарзан багийн төвийн тохижилтын ажлыг эхлүүлэхээр гэрээ байгууллаа.

Мөст сум: Ковид -19 халдварт өвчинтэй тэмцэх Улс, аймгийн онцгой комиссын шийдвэрийн хүрээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж сумын онцгой комисс ажиллах хуваарь гарган иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт хийж төрийн албан хаагчид постонд гарч ажиллалаа. Ард иргэдийг мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх арга, ариутгал халдваргүйжүүлэх, амны хаалт зүүлгэж хэвшүүлэх маскжуулах ажлыг зохион байгуулж, аймгийн оёдлын цехээс 920ш амны хаалт, сумын ЗДТГ-ын эмэгтэйчүүд санаачлагаар 500 амны хаалт оёж иргэдэд хүргэж ажилласнаас гадна гарын авлага боршуурыг айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллага, гудамж талбай, хашаа хороо, мэдээллийн самбарт байршуулж мэдээлж ажиллав. Сумын гудамж талбай, аж ахуйн нэгж, албан байгууллагын гадна орчинд ариутгал халдваргүйтгэл хийлээ.

Иргэний бүртгэл мэдээлэлд төрөлт-7, гэрлэлт цуцлалт-2, овог нэр өөрчлөлт-1, нас баралт-2, иргэний үнэмлэх-18, лавлагаа-19 хийгдэж нийт 49 иргэнд үйлчиллээ.

Усны шувууд нүүдэллэн ирж байгаатай холбогдуулан цэцэг нуурын ойр орчим байгаа айл өрх болон сумын нийт ард иргэдэд сэрэмжлүүлэг өгч шувууны томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл түгээн ажиллаж байна. Зэрлэг амьтаны төллөлтөд анхаарч Давст, Тавт чиглэлээр ажиглалт хийлээ.

Мөнххайрхан сум: Засаг даргын Тамгын газрын аппаратын шуурхай хуралдааныг 2, Онцгой комиссын хурлыг 2 удаа хуралдуулж, ковид-19 өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, иргэдээ короновирусын

халдвараас урьдчилан сэргийлэх талаар тухай бүр шийдвэр гарган хэрэгжүүлж, аймаг, сум, баг хоорондын хөдөлгөөнийг хориглох тухай захирамж гаргаж, 3 цэгт хяналтын пост гаргаж, 3 гэр барьж, 40 гаруй төрийн албан хаагчдыг дайчлан ажиллуулав.

Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд дайчлахаар заасан хүн хүч, техник хэрэгслийн тооцоо, хангалт, зохион байгуулалт, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн гүйцэтгэх үүрэг, ажиллах, цугларах газар, цаг хугацааг тодорхой тусгаж тодотгол хийсэн. Сумын хүн ам, эдийн засгийн холбогдолтой тоон мэдээллүүдийг шинэчилсэн. Онцгой комиссын бүрэлдэхүүн, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан шинэчилж баталсан.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед сумын Онцгой комисс, ЗДТГ, Эмнэлгийн байгууллага, Цагдаагийн ажилтнуудын уялдаа холбоог сайжруулж, мэдээ мэдээллээр шуурхай ханган ажиллаж, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангид хээрийн майхан 1 ширхэгийг шинээр худалдан авч бэлэн байдлыг хангасан. Суманд үйл ажиллагааг явуулдаг караоке 1, 3 тоглоомын газрын үйл ажиллагааг сумын Засаг даргын 2020 оны А/14 дүгээр захирамжаар түр зогсоосон.

Сумын Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн “Хязгаарлалт тогтоох тухай” А/32 дугаар захирамжаар сумын хэмжээнд худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдэд цагийн хязгаарлалт хийж, 2 дугаар сарын 21-ны өдрөөс 3 дугаар сарын 30-ний өдрийг хүртэл өглөө 10:00 цагаас орой 16:00 цаг хүртэл ажиллуулахаар тогтоож, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/155 дугаар захирамж, сумын Засаг даргын согтууруулах ундааг худалдан борлуулах хугацааг сунгах тухай захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр ажлын хэсэг ажиллаж, архи согтууруулах ундааны зөвшөөрөлтэй 6 дэлгүүрийн согтууруулах ундааг тоолж, хүлээн авч хурааж, лацдав. Мөн барааны зохиомол өсөлт үүсгэхгүй байх, хүнсний хадгалалт, хугацаа, хамгаалалтад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулж, зөвлөмж өгөв.

Сумын даргын Тамгын газрын ажилтнууд, төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх зорилгоор 2019 оны ангийн орлогын эх үүсвэрээс пургон машин 1, олон үйлдэлт принтер 3, залгуур 6, сандал 8 ширхэг, Тамгын газрын даргад ширээний компьютер, хэвлэгч тус бүр 1 ширхэгийг шинээр худалдан авч нийлүүллээ.

Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох зар мэдээ тавьж, 03 дугаар сарын 09-ний өдөр төсөл сонгон шалгаруулах зөвлөл хуралдаж, 5 иргэнд 11.0 сая төгрөгийг үйлдвэр үйлчилгээ эрхлэх, ажлын байр бий болгох зорилгоор зээл олгов. Мөн 2019-2020 онд зээлд хамрагдсан 22 иргэний мэдээллийг сум хөгжүүлэх сангийн програмд шинэчлэн орууллаа.

Жил бүрийн 03 дугаар сарын 03-нд Дэлхийн байгалийн амьтан, ургамал хамгаалах өдөр, 03 дугаар сарын 21-нд Дэлхийн ойн өдөр, 03 дугаар сарын 22-нд

Дэлхийн усны өдөр, 03 дугаар сарын 23-нд Цаг уурын өдөр, 03 дугаар сарын 2 дахь долоо хоногийн Пүрэв гаригийг Гамшгаас хамгаалах дохиогоор ажиллах дадлага сургуулилт, 03 дугаар сарын сүүлийн долоо хоногийн бямба гаригт Эх дэлхийн цаг зэрэг олон тэмдэглэлт өдрүүд тохиодог эдгээр тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд Алаг багийн Тасын нуруунд хяналтын автомат камерын картны мэдээлэл авах, мониторинг судалгаа хийх, био техникийн арга хэмжээ авах зэрэг ажлуудыг хийлээ.

Янгир ямааны байршил болох Тасын нурууны Түймэртийн оройд 150 кг хужир шүү тавьж, мониторинг судалгаагаар бүс нутагт нийт 110 гаруй янгир, 25 тэх тоологдон хяналтын камерт Янгир, Буга, Үнэг болон мотоцикл унасан буу үүрсэн давхардсан тоогоор 8 иргэний зураг бичлэг орсон байсан. Камерт орсон иргэдтэй уулзаж автомат хяналтын камерын талаар мэдээлэл өгч сануулах арга хэмжээ авлаа.

Хууль бусаар Барагшун бэлтгэсэн тухай мэдээллийн дагуу хяналт шалгалт хийж, STEWER маркийн ХОА 38-23 дугаартай тээврийн хэрэгсэлээр тус сумын иргэн Т.Баасай хууль бусаар Барагшун бэлтгэж зарахаар тээвэрлэж явсныг Манхан сумын замын цагдаагийн пост болон ажлын хэсгийн бүрэлдэхүүн тус зөрчлийг илрүүлж аймгийн Цагдаагийн газарт мэдэгдэн уг хэргийг шалгуулж байна.

Хаваржилтын нөхцөл байдалтай танилцаж, иргэдэд цаг үеийн мэдээлэл хүргэх, санал хүсэлтийг сонсох ажлаар хөдөөгийн 4 багт малчдыг эргэх 4 ажлын хэсэг гарч, 03 дугаар сарын 05-10-ны өдрүүдэд ажиллав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нийт 400 гаруй айл өрхүүдээр орж, хууль, тогтоомж, төрийн үйлчилгээний талаар танилцуулж, санал хүсэлтийг нь сонсож, багийн эмч иргэддээ үзлэг хийж, эм, эмнэлгийн үйлчилгээ үзүүлж, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгч, хялбаршуулсан 1500 гаруй тараах материал бэлтгэн айл өрхүүдэд хүргэж ажиллав.

Сумын эрсдлийн сан, багуудын малчдын бэлчээрийн эрсдлийн сангаас өвс тэжээл нөөцөлж, малячад хүргүүлэх ажлыг зохион байгуулж, энэ сард 200 уут тэжээл хөнгөлөлттэй үнээр нийлүүллээ.

Төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг 7 хоног тутам аймгийн ХХААГ-т хүргүүлж, 25-ны байдлаар бог малын төллөх хээлтэгчийн 48.0 хувь нь төллөж гарсан төлийн 99,5 хувь нь эсэн мэнд бойжиж байна

Сумын Эрүүл мэндийн төвд нийт 32 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Төрсөн эх-1, Эмийн бус эмчилгээгээр 26 хүнд үйлчилсэн. Урьдчилан сэргийлэх зорилгоор: 0-2 насны 32 хүүхдэд товлолын дагуу дархлаажуулалтанд 100 хувь хамруулсан. Элэг бүтэн-Монгол үндэсний хөтөлбөрийн хүрээнд В вирусын сайн дурын вакциныг 10 хүнд захиалан авч дархлаажуулсан.

Улирлын томуугийн дэгдэлт, шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор албаны өндөржүүлсэн бэлэн байдалд хариуцлагатай жижүүр томилогдон өдөр бүр уртасгасан цагаар ажиллаж мэдээгээ эрүүл мэндийн газарт өгч, аймаг, хотоос ирж байгаа иргэдэд хяналт тавин ажиллаж байна.

Эмнэлгийн тусгаарлах өрөөний эм, хэрэгслийн нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангаж ажилласан. Үүнд: тусгаарлах өрөөнд 7 ширхэг нэг удаагийн хувцас,

N95 маск 5 ширхэг авсан. Эрүүл мэндийн төвд хандив болгож Энхжаргалын Баттулга 15 ширхэг гар халдваргүйжүүлэх уусмал, Цэрэн-Адьяагийн гэр бүлээс зайнаас халуун хэмжигч өгч хандив, дэмжлэг туслалцаа үзүүлсэн.

Амбулаторийн үзлэгийг гэрийн үзлэгт шилжүүлж багийн бага эмч нар гэрээр эмнэлгийн тусламж үзүүлсэн. Томуу, шинэ короновирусаас сэргийлэх хулдаасан хэвлэл нийт 14 ширхэгийг хэвлүүлж албан байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлсэн. Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгчдэд маск тогтмол зүүлгэж, ариутгал халдваргүйтгэл, гар угаах зөвлөмжийг өдөр бүр өгч ажиллалаа.